



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC



Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент төсөл

Төслөөс 2008 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Н.Батжаргал- төслийн үндэсний менежер
2009-03-24

Төслийн тухай товч

Санхүүжүүлэгч байгууллага:

- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
- Нидерландын Засгийн Газар
- Даян Дэлхийн Байгаль Орчны Сан

Хэрэгжүүлэгч байгууллага:


ХХААЯ, БОЯ

Төсөв:

4,1 сая ам. Доллар /2.3 сая Нидерландын засгийн газраас/

Хэрэгжих хугацаа:

2008-2012 он



Ажлын төлөвлөгөөний биелэлт

- 2008 онд 52 ажил төлөвлөснөөс 46 ажил биелэгдэж төлөвлөгөөний биелэлт 88,5 хувьтай байна.
- 6 үйл ажиллагаа 2009 онд хийхээр хойшлогдсон

2008 оны төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд ба эдгээрт төсөвлөсөн хөрөнгө

Үйл ажиллагааны чиглэл	Төсөв		Гүйцэтгэл	
	Ам.доллар	Хувиар	Ам.доллар	Хувиар
1. Цөлжилттэй тэмцэх, ГТМ-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохицуулалтын механизмыг сайжруулж, байгууллагын болон хүний нөөцийн мэдлэг, чадавхи бэхжсэн байх	333914	45.7%	288475	39.5%
2. ГТМ-ийг дэмждэг үндэсний стратеги, бодлого болон зохицуулалтын тогтолцоог бий болгох	23540	3.2%	28651	3.9%
3. Ой, ус, бэлчээрийн цогц менежмент (сильвопасторализм) нэвтрүүлэх үйл ажиллагааг туршин хэрэгжүүлж, үзүүлэн сургалт зохион байгуулах замаар нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн нэгдсэн менежментийг түгээн дэлгэрүүлэх	209201	28.6%	115258	15.8%
5. Үйл ажиллагааны зардал	164524	22.5%	176157	24.1%
Нийт	731179	100%	608541	83%

1. Төслийн бүтэц, зохион байгуулалт

- 2008 оны 3-р сард төслийн менежментийн баг бүрдэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн
- 13 суманд төслийн нэгжийг байгуулж, төслийн орон нутгийн зохицуулагч, жолооч нарыг шалгаруулан ажилд оруулаад байна.
- Төслийн удирдах болон техникийн зөвлөлийг зохих журмын дагуу байгуулж, хагас цагаар ажиллах төслийн аймгийн зохицуулагч нарыг аймагтай зохицон томилон ажиллуулж байна.

2. ГТМ, цөлжилттэй тэмцэх ажлыг сурталчлах байгууллагын болон хүний нөөцийн чадавхийг сайжруулах, зохицуулалтын механизмыг бэхжүүлэх талаар

1. Аймаг, сум орон нутгийн холбогдох ажилтнуудын болон яамд, их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудын ГТМ ба ЦТ чадавхийг дээшлүүлэх зорилгоор дараахь сургалтуудыг зохион байгуулав. Үүнд:
 - Бороо цасны усыг хуримтлуулан хөв байгуулах арга технологи /26 хүн/
 - Мод тарих арга технологи /160 хүн/
 - Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчилсэн зааврын дагуу боловсруулах аргачлалыг эзэмшүүлэх /21 хүн/
 - Малчдын бүлэг, нөхөрлөл зохион байгуулах /656 хүн/
 - Бэлчээрийн менежментийн талаар /567 хүн/
 - Гар аргаар тэжээл бэлтгэх /136 хүн/

-Үргэлжлэл-

2. Гео-экологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны төвийн хүний нөөц, техникийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг эхэлж, тус төвийн судалгаа, суртчилгааны чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө хийх семинарыг зохион байгуулж ойн зурвас байгуулах, технологи дамжуулах, силвопасторализмын чиглэлээр ажиллах 3 ажилтанг нэмж ажиллуулах зардлыг төслөөс шийдвэрлээд байна.
3. Төслийн хугацаанд (2008-2012) зохиогдох сургалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж төслийн техникийн зөвлөлийн хурлаар батлуулан мөрдөж байна. Уг төлөвлөгөөнд сургалтын сэдэв, зорилтот бүлэг, оролцогч, тооцоолсон үр дүн, зохиогдох газар, хугацааг багтаасан болно.

3. ГТМ-ийг улсын, аймгийн, орон нутгийн бодлогод тусгах, стратеги зохицуулалтын хүрээг бэхжүүлэх талаар

- Бэлчээрийн менежментийн туршилтын хэлтсийн үйл ажиллагааг санхүүгийн хувьд дэмжиж байсан бөгөөд тус хэлтэс ХХААХҮЯ-ны шинэ бүтцэд багтан үйл ажиллагаагаа явуулж байна.
- Бэлчээрийн тогтвортой менежмент төслийн хүрээнд байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй бүлгүүдийн үйл ажиллагаатай танилцах аялалд төслийн сумдын зохицуулагчид, идэвхтэй малчдыг хамруулсан /43 хүн, СЭ, ӨВ – 4 сум/
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын холбогдох газар, албадын чадавхыг бэхжүүлэх стратеги, түүнийг хэрэгжүүлэх тодорхой хөтөлбөрийг олон улсын зөвлөлтэй хамтран боловсруулаад байна.

4. Байгалийн нөөцийн ялангуяа бэлчээр, усны менежмент, силвопасторализмын талаар иргэдэд түшиглэсэн арга замыг турших, үзүүлэх сургууль зохиох

- Сүхбаатар, Өвөрхангай аймгийн 6 суманд салхины хүчийг бууруулах ойн зурвас, ой бэлчээрийн цогц систем /silvopasture/ байгуулах зорилгоор орон нутагт богино хугацааны зөвлөхүүдийн баг ажиллаж тухайн сумдад ойн зурвас байгуулах газруудыг сонгож, зурвасны хийц, тариалах мод, ургамлын төрөл зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсаад байна. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2009 оноос эхлэнэ.
- Түлшний шинэ эх үүсвэр бий болгох, үр ашигийг нэмэгдүүлэх, нар салхины эрчим хүчийг ашиглах замаар заг болон бусад мод бутыг ахуйн зориулалтаар хайр гамгүй хэрэглэх байдлыг бууруулах зорилгоор үнэлгээ судалгааны ажлыг үндэсний зөвлөхүүдийн баг хийгээд байна. Энэ судлагааны дагуу 2009 оноос түлш хэмнэх, үр ашгийг нэмэгдүүлэх, шахмал түлш үйлдвэрлэх талаар жижиг туршилтын ажлууд хийгдэх юм.

-Үргэлжлэл-

- Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Цөлжилтийг сааруулах” төсөлтэй хамтарч 6-р сарын 17-нд зохиогддог Дэлхийн цөлжилттэй тэмцэх өдрийн тухай олон нийтэд өргөн мэдээлэв.
- Заг, харгана, жигд, чацаргана, сухай, хайлаас тарих гарын авлага, газар өмчлөлтэй холбоотой тохимол, бэлчээрийн газарзүй экологийн нөхцөл ном зэргийг боловсруулан хэвлэж нийтийн хүртээл болгоод байна. Түүнчилэн Бэлчээрийн Тогтвортой Менежмент төслийн хүрээнд боловсруулсан бүлэг байгуулах, говь хээрийн бүсэд гар худаг гаргах, дорйтсон бэлчээрийг сэргээх, дарш бэлтгэх талаар гарсан гарын авлагыг дахин хэвлүүлж төслийн малчдад тараан өгөөд байна.